



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 6/36

Хэрлэн сум

С.Оюун-Эрдэнийг шилжүүлэн
томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, агентлаг хариуцсан мэргэжилтэн Сумъяагийн Оюун-Эрдэнийг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр шилжүүлэн томилсугай.

2. С.Оюун-Эрдэний цалинг ТЗ-6-5 шатлалаар тогтоон, үндсэн цалинг 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 18 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэн, Төрийн албаны тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг С.Оюун-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР